



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/26

Арвайхээр сум


**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 23/14 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Улаан загалмайн хорооны гадна металл фасадны ажлын зураг төсвийн үнэ 2,814,000 (хоёр сая найман зуун арван дөрвөн мянга) төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалтын өрөөний засварын ажлын зураг төсвийн үнэ 1,476,000 (нэг сая дөрвөн зуун далан зургаан мянга) төгрөг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дотрын тасгийн засварын ажлын зураг төсвийн үнэ 3,380,000 (гурван сая гурван зуун наян мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 7,670,000 (долоон сая зургаан зуун далан мянга) төгрөгийн зардлыг аймгийн 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан Зураг төсөл боловсруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

**6224 11 0058**